

ХЭРЭГЛЭГЧДИЙН ИНФЛЯЦИЙН ХҮЛЭЭЛТИЙН ТҮҮВЭР СУДАЛГААНЫ ҮР ДҮН

Түүвэр судалгаанд Улаанбаатар хотын 9 дүүргийн 135 хорооноос 1004 иргэдийг санамсаргүй түүврийн аргачлалаар сонгож хамрууллаа. Судалгааны зарим үр дүнгээс дурдахад иргэд инфляцийг 3 сарын дараа **16.02%**, хагас жилийн дараа **16.23%**, 3-н улирлын дараа **16.74%**, жилийн дараа **16.87%** болж, 8-р сарын инфляцийн түвшингээс өсөхөөр хүлээж байна. Мөн үнийн өсөлтийг тодорхой тоон заагуудаас асуухад иргэд инфляцийг жилийн дараа дунджаар **10.7%** болно гэж үзжээ.

СУДАЛГААНД ОРОЛЦОГЧДЫН ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ


- Судалгаанд оролцогчдын 65.9% нь эмэгтэй;
- Насны бүтцийг харвал 53.2% нь 25-44 насныхан;
- Боловсролын түвшингээр авч үзвэл 84.8% нь бүрэн дунд болон дээд боловсролтой;
- Ам бүлийн тоог харвал 83.9% нь 2-5 ам бүлтэй;
- Ажил эрхлэлтийн байдлыг авч үзвэл 43.7% нь хувийн салбарт ажилладаг, 13.3% нь төрийн албанд, 35% нь ажилгүй;
- Өрхийн орлогын зүгээс харвал 48.1% нь 200-600 мянган төгрөгийн орлоготой, 8.9% нь 200 мянгаас бага, 43.0% нь 600 мянган төгрөгөөс дээш орлоготой өрхүүд байлаа.

Зураг 1.1: Жилийн инфляцийн хүлээлтийн чиглэлийн индекс



Санамж: Чиглэлийн индекс нь [-1; 3] хооронд утга авах бөгөөд [-1;0] үнэ буурна, [0] үнэ өөрчлөгдөхгүй, [0;1] инфляци одоогийнхоос буурна, [1;2] инфляци одоогийнхтой адил түвшинд байна, [2;3] инфляци одоогийнхоос хурдан өснө.

Зураг 1.2: Ирэх 12 сарын хугацаанд үнийн түвшин хэрхэн өөрчлөгдөх вэ?



1. Хүлээлтийн ерөнхий хандлага


Чиглэлийн индекс нь иргэдийн инфляцийн хүлээлтийн хандлагыг харуулах бөгөөд Хүлээлтийн судалгааг авч эхэлсэнээс хойшхи хугацааны туршид иргэдийн хүлээлтийн чиглэлийн индексийн дундаж утга нь 1.85, стандарт алдаа нь 0.15 нэгж байна. 2011 оны 12-р сард хүлээлтийн индекс 2 гарсан нь тухайн үед инфляци болон ханшийн түвшин өссөнтэй холбоотой.

Зураг 1.1-ээс харахад 2012 оны 9-р сарын байдлаар иргэдийн хүлээлтийн индекс 1.82 буюу “инфляци одоогийнхтой адил түвшинд байна” гэж үзэх хандлагатай гарсан байна. Энэ нь дундаж утгасаа 0.03 нэгжээр буурсан дүнтэй байна. Хүлээлтийн индекс нь инфляци одоогийнхтой адил түвшинд байна гэсэн бүсэд байгаа нь инфляцийн түвшин хоёр оронтой тоонд¹ байгаагаар шууд холбоотой.

Хүлээлтийн чанарын хариулт (Зураг 1.2) – аас харвал иргэдийн 73.3% нь ирэх 12 сард үнийн түвшин ерөнхийдөө өснө гэж үзсэн бөгөөд үүнээс 34.7% нь үнийн түвшин хурдацтайгаар өснө гэж хариулжээ. Энэ нь өмнөх судалгааны дүнгээс 4.3 нэгжээр буурсан байна.

¹ 2012 оны 8-р сард Улаанбаатар хотын инфляци 15.6% байсан.


Зураг 2.1: Жилийн инфляцийн хүлээлт



2. Инфляцийн хүлээлтийн тоон утга

Иргэдийн инфляцийн хүлээлтийг тооцоходоо одоогийн инфляцийн түвшинг суурь болгон ашигласан². **Зураг 2.1**-ээс харахад хүлээлт нь сүүлийн судалгааны дүнгээр 16.87% буюу иргэд жилийн дараа инфляци одоогийн түвшнээсээ бага зэрэг өснө гэж үзсэн байна.


Зураг 3.1: Хүлээлтийн түвшин, тоон хариулт (ирэх 12 сарын хугацаанд)



3. Инфляцийн хүлээлтийн тоон хариулт

Иргэдийн 12 сарын дараах хүлээлтийн түвшинг тодорхой тоон завсраас асуух замаар тооцоолол хийлээ. **Зураг 3.1**-ээс харахад судалгаанд оролцсон иргэдийн 24% нь инфляцийг 12 сарын дараа 9-11%-д, 27% нь 7-9%-д, 7% нь 5-7%-д, 12% нь 11-13% байна гэж үзсэн бөгөөд иргэдийн тоон хариултуудын дундаж утга буюу иргэд 12 сарын дараа инфляцийг **10.6%** байна гэж хүлээж байна.

Зураг 4.1: Иргэдийн 12 сарын дараах хүлээлтийн харьцуулалт




4. Хүлээлтийн харьцуулалт

Иргэдийн улирлын хүлээлтийн тоон утгуудыг харьцуулан **Зураг 4.1**-ээс харвал гурван сарын дараа хүлээлтийн дүн 16.02% -тай байна. Харин 6 сарын дараа буюу ирэх оны 3-р сарын эцсээр хүлээлтийн дүн 16.23% байна. 9 сарын дараа хүлээлт 16.74% байх төлөлтэй бол жилийн хүлээлтийн түвшинг харвал хүлээлт 16.8% болсон байна. Иргэдээс авсан тоон утгыг харвал жилийн дараа инфляци 10.6% болно гэж хариулжээ. Тоон хариулт, хүлээлтийн утгуудын хоорондын зөрүүтэй байдал ялгаатай аргачлалаар тооцсонтой холбоотой.

² 2012 оны 8-р сарын байдлаар инфляцийн түвшин 15.6% байсан.

Зураг 5.1: Таны бодлоор ирэх 12 сарын хугацаанд банкны зээлийн хүү хэрхэн өөрчлөгдөх вэ?




Зураг 5.2: Зээлийн хүүний хүлээлтийн индекс болон зээлийн хүү



Санамж: Чиглэлийн индекс нь [-1;1] завсарт утгаа авна. [0;1] өснө, [0] хэвэндээ байна, [0;-1] буурна.

Зураг 5.3: Таны бодлоор ирэх 12 сард төгрөгийн ханш хэрхэн өөрчлөгдөх вэ?




5. Бусад асуултуудын хариулт

Судалгаанд оролцогчдын 26.1% нь ирэх 12 сарын хугацаанд зээлийн хүү өснө гэж үзсэн нь 6-р сарын судалгааны дүнгээс 7.5 нэгжээр буурсан хэдий ч өмнөх судалгааны дүнгүүдтэй харьцуулахад өндөр хэвээр байгааг **Зураг 5.1-ээс** харах боломжтой. Мөн 6-р сарын судалгааны үр дүнтэй харьцуулахад зээлийн хүү хэвэндээ байна гэсэн хариулт бага 4.7 нэгжээр өсч, хүү буурна гэсэн хариулт бага зэрэг өссөн дүнтэй гарсан байна.

Сүүлийн үед эдийн засагт инфляцийн дарамт нэмэгдэж буйтай холбоотойгоор Төв Банк бодлогын хүүгээ хэд хэдэн удаа өсгөснөөр арилжааны банкууд хүүгээ өсгөж, зээл олголтоо хумих болсон. Энэ нь иргэдийн хүүний талаарх хүлээлтийн хандлагыг өөрчилж буй нэг хүчин зүйл болж байна (**Зураг 5.2**).

Судалгаанд оролцсон иргэдийн 26.3% нь ирэх нэг жилд төгрөгийн ханш чангарна гэж үзсэн нь 3-р сарын судалгааны дүнтэй харьцуулахад 15 нэгжээр буурсан дүнтэй байна. Харин эсрэгээрээ төгрөгийн ханш суларна гэж үзсэн иргэдийн хувь 41.8% байгаа бөгөөд 6-р сарын судалгааны дүнгээс (**Зураг 5.3-оос** харна уу) 4.8 нэгжээр өссөн дүнтэй байна.


Зураг 5.4: Төгрөгийн ханш болон төгрөгийн ханшийн чиглэлийн индекс



Санамж: Чиглэлийн индекс нь [-1;1] завсарт утгаа авна.]0;1] ханш суларна, [0] хэвэндээ байна,]0;-1] чангарна.


Иргэдийн төгрөгийн ханшийн хүлээлтийн чиглэлийн индексийг харвал энэ удаагийн судалгааны дүнгээр ханш суларна гэсэн хүлээлттэй гарсан байна. Мөн төгрөгийн ам.доллартой харьцах албан ханшийн тоон мэдээнээс харвал 2011 оны эцэст нэрлэсэн ханш 11%-иар сулраад байсан бол 2012 оны 9-сарын 17-ны байдлаар 1,399.27 болж сулрах хандлагатай болж байна (Зураг 5.4).

Зураг 5.5: Таны бодлоор ирэх 12 сард хадгаламжинд мөнгө хийхэд тохиромжтой үе мөн үү?




Зураг 5.5-ээс харахад судалгаанд оролцогчдын 38.2% нь ирэх 12 сарын хугацаанд хадгаламжид мөнгөө байршуулахгүй гэж үзэж байна. Харин мөнгөө байршуулах иргэдийн хувь 6-р сарын судалгааны дүнгээс 7.6 нэгжээр буурч 19.8%-д хүрчээ.

Зураг 5.6: Танай өрхийн санхүүгийн байдал ирэх 12 сарын хугацаанд хэрхэн өөрчлөгдөх вэ?



Ирэх 12 сарын хугацаанд иргэдийн өрхийн санхүүгийн байдал сайжирна (Зураг 5.6) гэж судалгаанд оролцогчдын 26.0% хариулсан нь өмнөх улирлын судалгааны дүнгээс 8.6 нэгжээр буурсан бөгөөд бусад судалгаануудтай харьцуулахад өндөр дүнтэй байна. Харин хэвэндээ байна, муудна гэсэн хариултуудын хувь өмнөх судалгаанаас 3.9 нэгжээр өсч 53.0%-д хүрсэн ба үүнээс муудна гэсэн хариултын хувь 10.4%-д хүрсэн байна.

Зураг 5.7: Өрхийн санхүүгийн байдлын талаарх хүлээлтийн чиглэлийн индекс



Санамж: Чиглэлийн индекс нь [-1;1] завсарт утгаа авна.]0;1] өрхийн санхүүгийн байдал сайжирна, [0] хэвэндээ байна,]0;-1] муудна.

2008 оны эцэст хийгдсэн судалгааны дүнгээр иргэдийн дийлэнх нь ирэх 12 сарын хугацаанд өрхийн санхүүгийн байдал нь муудна гэж үзэх хандлагатай байсан бол 2009 оны 9-р сараас хойш хийгдсэн судалгаануудаар ирэх 12 сард сайжирна гэсэн хандлага давамгайлах болсон байна. Чиглэлийн индекс 2012 оны 6-р сарын судалгааны дүнгээр өмнөхөөс буурч гарсан бөгөөд мөн энэ удаагийн судалгаагаар 0.13 нэгжийн бууралттай гарлаа. **Зураг 5.7**-аас харахад иргэд өмнөх судалгааны дүнтэй харьцуулахад 2012 оны 9-р сарын байдлаар өрхийн санхүүгийн байдал муудна гэсэн хүлээлттэй байна.

Зураг 5.8: Сайжрах бол шалтгаан нь юу вэ?



Өрхийн санхүүгийн байдал сайжирна гэж судалгаанд оролцсон иргэдийн 26.0% нь хариулсан бөгөөд тэдгээрийн 41.1% ирэх 12 сард цалин болон бизнесийн орлого нэмэгдэнэ гэж үзсэн байна. Мөн 10.4% нь үл хөдлөх хөрөнгийн үнэ өснө гэж хариулсан нь иргэдийн эзэмшиж буй үл хөдлөх хөрөнгийн үнэлгээ өсч, түүнээсээ орлого олно гэж үзсэн (**Зураг 5.8**-оос харна уу) байна. Үүнээс гадна иргэдийн 22.9% нь өрхийн гишүүн ажлын байртай болно гэжээ.

Зураг 5.9: Муудах бол шалтгаан нь юу вэ?



Зураг 5.9-аас харахад өрхийн санхүүгийн байдал муудна гэж иргэдийн 15.4% нь хариулсан бөгөөд тэдгээрийн 33.0% нь ирэх 12 сарын хугацаанд үнэ өссөнөөс шалтгаалан өрхийн санхүүгийн байдал муудна гэж үзжээ. Харин 21.2% нь цалин болон бизнесийн орлого буурна, 13% өрхийн гишүүн ажилгүй болно, мөн 5.5% нь татварын ачаалал ихэснэ гэж үзжээ.

ДҮГНЭЛТ

Инфляцийн хүлээлтийн ерөнхий хандлага буюу чиглэлийн индекс буурч “инфляци одоогийн түвшиндээ байна” гэсэн мужид байна. 1 улирлын дараа одоогийн түвшнээс өсч 16.02% орчимд, 6 сарын дараа 16.23%, 9 сарын дараа 16.74% орчимд байхаар хүлээж байгаа бол жилийн дараа 16.87% орчимд байна гэж хүлээж байна. Бусад асуултуудын дүнгээр ирэх 12 сарын хугацаанд зээлийн хүү буурч, төгрөгийн ханш суларна гэж үзсэн байна.

Түүнээс гадна ирэх жилд өрхийн санхүүгийн байдал сайжирна гэж нийт судалгаанд оролцогчдын 26% бөгөөд тэдгээрийн дийлэнхи нь цалин, бизнесийн орлого нь өснө, үл хөдлөх хөрөнгийн үнэ өснө, өрхийн гишүүд ажлын байртай болно гэсэн хүлээлттэй байна. Харин арван таван хүн тутмын нэг нь өрхийн санхүү муудна гэж хариулсан бөгөөд тэдгээрийн 33% нь ирэх 12 сарын хугацаанд үнийн өсөлтөөс шалтгаалан өрхийн санхүүгийн байдал муудна гэж хариулжээ. Ирэх 12 сарын хугацаанд иргэдийн дийлэнх нь хадгаламжинд мөнгө хийхэд тохиромжгүй болон мэдэхгүй гэж үзсэн хэвээр байна.